**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

# Гурванбулаг сумын ерөнхий боловсролын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БНА-2024/59/НА- СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Баянхонгор хот

2023 оны 02 дугаар сарын 20-ний өдөр

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын

Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Ахлах аудитор М.Алтантуяа

Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Должмаа

Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр: “Номгон Аудит” ХХК

Захирал: Г.Саранчимэг

Аудитор:: О.Мандах

Утас: 89010203 Цахим хаяг: audit.nomgon@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ..... 3
**Асуудлыг онцолсон хэсэг** ..... 3
**Аудитын гол асуудал** ..... 4
**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ..... 5
**3 . САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ..... 11
**4. АУДИТЫН ТАЙЛАН** ..... 15
**4.1 Ерөнхий зүйл** ..... 15
**4.2 Материаллаг байдал** ..... 15
**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт** ..... 15
**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** 15
**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт** ..... 16
**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт** ..... 16
**4.5.1 Завсрын аудитын талаар** ..... 16
**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал** ..... 16
**5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ..... 17
6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ..... 18

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| БШУС | Боловсрол, шинжлэх ухааны сайд |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| СТСХ | Санхүү, төрийн сангийн хэлтэс |
| НББББ | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584
Цахим шуудан:procurement. bayankhongor@audit.gov.mn

ГУРВАНБУЛАГ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Д.ЦЭЦГЭЭ ТАНАА

2024.02.23 № 2/51

танай________-ны № ________ -т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гурванбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Гурванбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн дүн нь гүйцэтгэлийн үе шатанд тооцсон материаллаг байдлын дүнгээс хэтэрсэн.

Тус сургуулийн захирлын “Багш ажилчдад хоолны хөнгөлөлт олгох” 2023 оны 12 сарын 14-ны өдрийн Б/70 дугаар тушаалаар төсвийн төлөвлөгөө батлагдаагүй байхад хоолны хөнгөлөлт 21,771,700 мянган төгрөг олгосон зөрчил илэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагад энэ хуулийн 44.5.1, 46.3 хамаарахгүй, 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт, УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга зөрчин үр дүнгийн урамшууллыг олгосон, Эрх ба үүрэг, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой

5020202

бус байдал үүсээгүй, 2023 онд 71802 хөтөлбөрийн 9 арга хэмжээний зардалд 1,116,021.6 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 1,062,579.9 мянган төгрөгийг зарцуулж, оны эцэст харилцах дансанд 58,884.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарчээ.

**Аудитын гол асуудал**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах,нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээх бөгөөд Гурванбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын 92 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 95.0 хувиар үнэлснийг дээд шатны байгууллагаас 93.0 хувьтай дүгнэсэн байна. Гурванбулаг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР Б.МӨНХБАТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан (төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **126,916,214.06** | **195,753,989.07** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 4,800,867.00 | 58,884,690.13 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 4,800,867.00 | 58,884,690.13 |
| **3121** | **Төгрөг** | 4,800,867.00 | 58,884,690.13 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 4,800,867.00 | 58,884,690.13 |
| **33** | **АВЛАГА** | 572,213.24 | 136,271.80 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 00.00 | 136,271.80 |
| **335** | **Бусад авлага** | 572,213.24 | 00.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 572,213.24 | 00.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 121,543,133.82 | 136,733,027.14 |
| **351** | **Түүхий эд материал** | 60,087,144.82 | 72,879,078.14 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 55,163,344.82 | 71,949,578.14 |
| 35130 | Эм боох материал | 4,923,800.00 | 929,500.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 52,785,989.00 | 55,183,949.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 6,690,552.00 | 4,483,302.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 30,179,637.00 | 31,940,647.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 00.00 | 4,060,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 15,915,800.00 | 14,700,000.00 |
| 35600 | Мал амьтад | 8,670,000.00 | 8,670,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,363,087,807.13** | **4,457,110,696.79** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,363,087,807.13 | 4,457,110,696.79 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,332,237,807.13 | 4,426,260,696.79 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,427,640,851.00 | 4,530,221,740.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -272,582,262.72 | -338,735,449.56 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 211,745,024.33 | 304,423,784.33 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -113,533,070.13 | -137,954,248.05 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 139,421,870.78 | 143,611,870.78 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -67,986,522.33 | -82,838,916.91 |
| 39217 | Ном | 7,531,916.20 | 7,531,916.20 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 30,850,000.00 | 30,850,000.00 |
| 39301 | Програм хангамж | 320,000.00 | 320,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -320,000.00 | -320,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 30,850,000.00 | 30,850,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,490,004,021.19** | **4,652,864,685.86** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **759,300.92** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 759,300.92 | 00.00 |
| **413** | **Өглөг** | 759,300.92 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,489,244,720.27** | **4,652,864,685.86** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,489,244,720.27 | 4,652,864,685.86 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 767,534,111.81 | 767,534,111.81 |
| 51101 | Өмч: - төрийн | 767,534,111.81 | 767,534,111.81 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 244,264,450.19 | 3,407,884,415.78 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 244,264,450.19 | 244,264,450.19 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 3,163,619,965.59 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 477,446,158.27 | 477,446,158.27 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,490,004,021.19** | **4,652,864,685.86** |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН /ТӨГРӨГӨӨР/

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **256,653,000.00** | **4,410,208,382.32** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **00.00** | **3,187,588,282.32** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 00.00 | 10,274,333.32 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 00.00 | 70,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 70,000.00 |
| **121** | **Хөрөнгийн орлого** | 00.00 | 3,177,313,949.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **256,653,000.00** | **1,222,620,100.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 189,470,000.00 | 1,116,021,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 189,470,000.00 | 1,116,021,600.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 67,183,000.00 | 106,598,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 67,183,000.00 | 106,598,500.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **245,461,175.18** | **1,246,588,416.73** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **245,461,175.18** | **1,246,588,416.73** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 245,461,175.18 | 1,246,587,343.73 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 146,593,812.29 | 805,155,856.97 |
| 210101 | Үндсэн цалин | 80,439,388.60 | 549,726,099.54 |
| 210102 | Нэмэгдэл | 34,350,683.43 | 216,813,119.89 |
| 210104 | Урамшуулал | 9,856,898.37 | 38,616,637.54 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 21,946,841.89 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 18,781,672.38 | 100,547,846.94 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 12,888,159.81 | 68,373,153.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,516,254.31 | 7,723,221.19 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,797,413.79 | 6,583,254.92 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 233,878.71 | 1,627,238.21 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,345,965.76 | 16,240,979.62 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 37,953,400.00 | 94,331,117.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,593,000.00 | 4,964,827.00 |
| 210302 | Түлш, халаалт | 36,019,150.00 | 87,893,178.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 341,250.00 | 1,473,112.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2,829,900.00 | 18,440,440.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,506,900.00 | 9,947,710.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 463,000.00 | 2,292,280.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 860,000.00 | 6,200,450.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 16,779,525.00 | 96,645,300.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 00.00 | 4,433,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 16,779,525.00 | 92,211,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 00.00 | 7,880,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 7,880,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 99,000.00 | 5,739,833.48 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 99,000.00 | 5,739,833.48 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 22,423,865.51 | 117,846,949.34 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 00.00 | 12,420,190.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 22,423,865.51 | 105,426,759.34 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 00.00 | 1,073.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 1,073.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **11,191,824.82** | **3,163,619,965.59** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **11,191,824.82** | **3,163,619,965.59** |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.3 АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

| Код | Үзүүлэлт | ӨМНӨХ ОН | ТАЙЛАНТ ОН |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **945,013,500.00** | **1,223,262,313.24** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,177,200.00** | **642,213.24** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,177,200.00 | 642,213.24 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 1,177,200.00 | 642,213.24 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,177,200.00 | 00.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 642,213.24 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **943,836,300.00** | **1,222,620,100.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 823,039,500.00 | 1,116,021,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 823,039,500.00 | 1,116,021,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 800,000.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 800,000.00 | 00.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 119,996,800.00 | 106,598,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 119,996,800.00 | 106,598,500.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **922,467,042.98** | **1,147,042,790.11** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **922,467,042.98** | **1,147,042,790.11** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **879,391,492.98** | **1,105,060,717.11** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 644,079,609.77 | 805,602,077.42 |
| 210101 | Үндсэн цалин | 453,086,794.30 | 549,726,099.54 |
| 210102 | Нэмэгдэл | 139,009,104.60 | 217,259,340.34 |
| 210104 | Урамшуулал | 23,618,913.74 | 38,616,637.54 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 28,364,797.13 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 80,115,014.54 | 100,997,199.21 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 51,018,291.35 | 68,373,153.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,021,041.43 | 8,169,106.87 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,842,831.62 | 6,586,721.51 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,036,248.57 | 1,627,238.21 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 12,196,601.57 | 16,240,979.62 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 79,455,678.97 | 94,657,427.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,204,628.97 | 4,964,827.00 |
| 210302 | Түлш, халаалт | 71,970,800.00 | 87,893,178.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,280,250.00 | 1,799,422.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 39,983,480.00 | 50,230,800.00 |
| 210502 | Хоол, хүнс | 39,983,480.00 | 50,230,800.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,000,000.00 | 11,940,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 11,940,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 7,782,700.00 | 5,856,833.48 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,977,200.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,805,500.00 | 5,856,833.48 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 26,975,009.70 | 35,776,380.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 17,621,274.70 | 26,990,880.00 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | |
|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,353,735.00 | 8,785,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **43,075,550.00** | **41,982,073.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 43,075,550.00 | 41,981,000.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 43,075,550.00 | 41,981,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 00.00 | 1,073.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **22,546,457.02** | **76,219,523.13** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **10,289,000.00** | **22,135,700.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **10,289,000.00** | **22,135,700.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 10,289,000.00 | 22,135,700.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 10,289,000.00 | 22,135,700.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-10,289,000.00** | **-22,135,700.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 12,257,457.02 | 54,083,823.13 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 4,800,867.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 4,800,867.00 | 58,884,690.13 |

## 2.4 АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 767,534,111.81 | 477,446,158.27 | 93,392,874.62 | 1,338,373,144.70 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **767,534,111.81** | **477,446,158.27** | **93,392,874.62** | **1,338,373,144.70** |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 151,444,265.16 | 151,444,265.16 |
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **767,534,111.81** | **477,446,158.27** | **244,264,450.19** | **1,489,244,720.27** |
| D01 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **767,534,111.81** | **477,446,158.27** | **244,264,450.19** | **1,489,244,720.27** |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **767,534,111.81** | **477,446,158.27** | **244,264,450.19** | **1,489,244,720.27** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 3,163,619,965.59 | 3,163,619,965.59 |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **767,534,111.81** | **477,446,158.27** | **3,407,884,415.78** | **4,652,864,685.86** |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 2.5 АУДИТЛАГДСАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан | ЗӨРҮҮ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,229,686,100.00 | 1,169,178,417.11 | 60,507,609.89 | 95.08 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,229,686,100.00 | 1,169,177,417.11 | 60,507,609.89 | 95.08 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,179,656,800.00 | 1,127,196,417.11 | 52,460,382.89 | 95.55 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 849,736,700.00 | 805,602,077.42 | 44,134,622.58 | 94.81 |
| 210101 | Үндсэн цалин | 580,242,200.00 | 549,726,099.54 | 30,516,100.46 | 94.74 |
| 210102 | Нэмэгдэл | 229,364,700.00 | 217,259,340.34 | 12,105,359.66 | 94.72 |
| 210104 | Урамшуулал | 40,129,800.00 | 38,616,637.54 | 1,513,162.46 | 96.23 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 106,217,400.00 | 100,997,199.21 | 5,220,200.79 | 95.09 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 72,227,800.00 | 68,373,153.00 | 3,854,647.00 | 94.66 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 8,497,400.00 | 8,169,106.87 | 328,293.13 | 96.14 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,797,900.00 | 6,586,721.51 | 211,178.49 | 96.89 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,699,500.00 | 1,627,238.21 | 72,261.79 | 95.75 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 16,994,800.00 | 16,240,979.62 | 753,820.38 | 95.56 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 94,657,500.00 | 94,657,427.00 | 73.00 | 100.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,964,800.00 | 4,964,827.00 | -27.00 | 100.00 |
| 210302 | Түлш, халаалт | 87,892,700.00 | 87,893,178.00 | -478.00 | 100.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,800,000.00 | 1,799,422.00 | 578.00 | 99.97 |
| **2105** | **Нормативт зардал** | 51,694,800.00 | 50,230,800.00 | 1,464,000.00 | 97.17 |
| 210502 | Хоол, хүнс | 51,694,800.00 | 50,230,800.00 | 1,464,000.00 | 97.17 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 11,941,000.00 | 11,940,000.00 | 1,000.00 | 99.99 |
| 210604 | Урсгал засвар | 11,941,000.00 | 11,940,000.00 | 1,000.00 | 99.99 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 7,493,600.00 | 5,856,833.48 | 1,636,766.52 | 78.16 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,636,600.00 | 00.00 | 1,636,600.00 | 0.00 |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,857,000.00 | 5,856,833.48 | 166.52 | 100.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 57,915,800.00 | 57,912,080.00 | 3,720.00 | 99.99 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 49,130,300.00 | 49,126,580.00 | 3,720.00 | 99.99 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 8,785,500.00 | 8,785,500.00 | 0.00 | 100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 50,029,300.00 | 41,981,000.00 | 8,048,300.00 | 83.91 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 50,029,300.00 | 41,981,000.00 | 8,048,300.00 | 83.91 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 50,029,300.00 | 41,981,000.00 | 8,048,300.00 | 83.91 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,224,256,700.00 | 1,222,620,100.00 | 1,636,600.00 | 99.87 |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,116,021,600.00 | 1,116,021,600.00 | 0.00 | 100.00 |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,116,021,600.00 | 1,116,021,600.00 | 0.00 | 100.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 106,598,500.00 | 106,598,500.00 | 0.00 | 100.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 106,598,500.00 | 106,598,500.00 | 0.00 | 100.00 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 1,636,600.00 | 00.00 | 1,636,600.00 | 0.00 |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,636,600.00 | 00.00 | 1,636,600.00 | 0.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 4,800,867.00 | -4,800,867.00 | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 58,884,690.13 | -58,884,690.13 | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1** | **1** | | |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | | |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | **46.00** | **46.00** | | |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | | |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 27.00 | 27.00 | | |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 16.00 | 16.00 | | |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | **351.00** | **351.00** | | |

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | **351.00** | **351.00** | | |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 351.00 | 351.00 | | |

## 3 . САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Гурванбулаг сумын ерөнхий боловсролын сургууль нь “Сургууль, дотуур байранд хүүхдэд ээлтэй эрүүл аюулгүй материаллаг болон нийгэм, сэтгэлзүйн таатай орчин бүрдүүлж, хүүхдийн эрхийг ханган ажиллана” гэсэн зорилтын хүрээнд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилтын 92 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, биелэлт 95.0 хувьтай тайлагнасныг дээд шатны байгууллагаас 93 хувьтай дүгнэсэн байна.

Боловсрол, шинжлэх ухааны яамнаас жил бүр дэвшүүлэн тавьсан зорилго зорилтыг хангах үүднээс байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулах чиг үүргийн дагуу Захирлын 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/01 дугаар тушаалаар Захиргаа аж ахуй, Сургалтын алба, үйлчилгээний алба гэсэн бүтэц зохион байгуулалттай 46 орон тоотой, 351 суралцагчтай үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг сургуулийн захирал Д.Цэцгээ, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Б. Шүрсайхан нар зурсан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд Засгийн газрын 2022 оны 3 дугаар сарын 2 өдрийн 91 дүгээр тогтоол “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай”, 2022 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” 131 дүгээр тогтоол, Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022 оны 05 дугаар сарын 12 өдрийн А/170 дугаар тушаал “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал” мөн 2022 оны 10 дугаар сарын 26 өдрийн А/430 “Багшийн ажлыг үнэлэх журам” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж ажиллаж байна.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын түвшинд гүйцэтгэл үр дүнд суурилсан урамшууллын тогтолцоог бүрдүүлэх, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл чанар үр дүнг улсын хэмжээнд нэгдсэн шалгуураар хөндлөнгөөс үнэлж гүйцэтгэлийн урамшуулал олгох,

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА 005 ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 24,039.9 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 2,268.2 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 21,771.7 мянган төгрөгийн 1 албан шаардлагыг төсөв захирагчид хүргүүлэв.

### 5.1 Төлбөрийн акт

**Илрүүлэлт:**

1. Тус сургуулийн захирал өөртөө шийдвэр гаргаж хоолны хөнгөлөлтийн 486.0 мянган төгрөгийг авсан.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсвийн захирагчаар 486.0 мянган төгрөгийг төлүүлж, төсөвт буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Хүчингүй болсон шийдвэрийг үндэслэн сургуулийн захирлын 2023 оны 11 дүгээр сарын 01 өдрийн Б/53, 54,55,56,57 тоот тушаалаар нэг багшид “Заах аргач багш”, дөрвөн багшид “Тэргүүлэх” мэргэжлийн зэрэг олгож зэргийн нэмэгдэлд 1,782.2 төгрөг олгосон байна

Энэ нь Дээрх тушаалуудыг үндэслэсэн Боловсрол соёл шинжлэх ухаан спортын сайдын 2018 оны 12 дугаар сарын 02 өдрийн А/812 дугаар тушаал нь Боловсрол шинжлэх ухааны сайдын 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/413 тоот тушаалаар хүчингүй болсон, Төсвийн тухай хуулийн 16.5.5 “Төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төсвийн захирагчаар 1782.2 мянган төгрөгийг төлүүлж, төсөвт буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

Сургуулийн төсөв төлөвлөгөө цалингийн зардалд хоолны мөнгө батлагдаагүй байхад захирлын 2023.12.14-ны өдрийн Б/70 дугаар тушаалаар нийт багш ажилчдад ажилласан хоногт тооцож хоолны мөнгө 21,771.7 мянган төгрөг олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэсэн заалтууд санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

Дээрх төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

005 ХЯЗГААРЛАЛТТАЙ ДҮГНЭЛТ

## 6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мян.төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлантай холбоотой зөрчил | | | | | | | | |
| Тус сургуулийн захирал өөртөө шийдвэр гаргаж хоолны хөнгөлөлтийн 486.0 мянган төгрөгийг авсан | 1 | 486.0 | 1 | 486.0 | | | | |
| Боловсрол шинжлэх ухааны сайдын 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/413 тоот тушаалаар хүчингүй болсон тушаал шийдвэрийг үндэслэж сургуулийн захирлын 2023 оны 11 сарын 01 өдрийн Б/53,54,55,56,57 дугаар тушаалаар 1 багшид "Заах аргач багш" 4 багшид "Тэргүүлэх"- мэргэжлийн зэргийн олгож зэргийн нэмэгдэлд 1782.2 мянган төгрөгийг олгосон. | 1 | 1,782.2 | 1 | 1,782.2 | | | | |
| Төсвийн төлөвлөгөө батлагдаагүй байхад цалингийн зардлаас тус сургуулийн захирлын 2023.12.14-ний өдрийн Б/70 дугаар тушаалаар нийт багш ажиллагсдад хоолны мөнгөнд 21,771.7 мянган төгрөг олгосон. | 1 | 21,771.7 | | | 1 | 21,771.7 | | |
| Нийт дүн | 3 | 24,039.9 | 2.0 | 2,268.2 | 1.0 | 21,771.7 | 0 | 0 |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан нягтлан бодогчид талархал илэрхийлье.

---oOo---

005 ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА ХЯЗГААРЛАЛТТАЙ САНАЛ ДҮГНЭЛТ